



**БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 1/02

Хөхбүрд

Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний шатах, тослох материал бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалтуудын үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний шатах, тослох материал бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:Б.Үлэмжсонин (Татварын Улсын байцаагч)

Гишүүд:Д.Эрдэнэбулган (Төсөвт төрийн сангийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:С. Ренцэнбямба (Сан хариуцсан нягтлан бодогч)

2.Тендер шалгаруулалтын холбогдох хууль, журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, авлига, ашиг сонирхолын зөрчилгүй ажиллахыг үнэлгээний хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д даалгасугай.



ДАРГА

Т.БЯМБАДОРЖ

042501319